



08

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 461

Улаанбаатар
хот

Улсын нөөцөөс бараа, материал
гаргах, нөхөн бүрдүүлэх тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11.5.1, Улсын нөөцийн тухай хуулийн 13.1.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Өвөлжилт хүндэрсэн зарим аймгуудад улсын нөөцөөс 50 хувь хямдруулан олгох өвс, тэжээлийн хуваарийг хавсралт ёсоор баталсугай.

2. Улсын нөөцөөс 50 хувь хямдруулан олгох өвс, тэжээлийн үнийн зөрүү болон тээврийн зардалд шаардагдах 3,908,604,835 (гурван тэрбум есөн зуун найман сая зургаан зуун дөрвөн мянга найман зуун гучин тав) төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд Б.Жавхланд зөвшөөрсүгэй.

3. Улсын нөөцөөс олгох өвс, тэжээлийг өвөлжилт хүндэрч байгаа сумдын малчдад оновчтой хуваарилж олгох, зориулалт бусаар зарцуулах, худалдаалахаас урьдчилан сэргийлэхэд хяналт тавих, гүйцэтгэлийн тайланг холбогдох баримтын хамт 2023 оны I улиралд багтаан Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлэхийг холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Улсын нөөцөөс олгосон өвс, тэжээлийг 2023 оны I улиралд багтаан тэжээлээр буцаан нөхөн бүрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Монгол Улсын Шадар сайд

С.АМАРСАЙХАН

Сангийн сайд

Б.ЖАВХЛАН

Засгийн газрын 2022 оны 461 дүгээр
ТОГТООЛЫН ХАВСРАЛТ



УЛСЫН НӨӨЦӨӨС ОЛГОХ ӨВС, ТЭЖЭЭЛИЙН ХУВААРЬ

№	Улсын нөөцийн байршил	Нэр төрөл	50% хямдруулан олгох		
			(Тонн)	Нийт үнэ (төг)	Хямдарсан үнэ (төг)
1.	Архангай аймаг	тэжээл	325.00	247,000,000	123,500,000
2.	Баянхонгор аймаг	өвс	295.90	250,923,200	125,461,600
		тэжээл	699.24	592,955,520	296,477,760
3.	Баян-Өлгий аймаг	тэжээл	683.90	588,154,000	294,077,000
4.	Говь-Алтай аймаг	тэжээл	795.86	737,762,220	368,881,110
5.	Завхан аймаг	тэжээл	1,267.80	1,153,190,880	576,595,440
6.	Дундговь аймаг	өвс	366.94	197,046,780	98,523,390
		тэжээл	570.20	427,650,000	213,825,000
7.	Ховд аймаг	өвс	9.80	5,880,000	2,940,000
		тэжээл	773.96	758,480,800	379,240,400
8.	Өмнөговь аймаг	өвс	460.78	426,221,500	213,110,750
		тэжээл	800.00	624,000,000	312,000,000
9.	Өвөрхангай аймаг	өвс	29.83	44,141,000	22,070,500
		тэжээл	778.82	610,006,871	305,003,435
10.	Төв аймаг	тэжээл	181.40	123,352,000	61,676,000
11.	Увс аймаг	өвс	7.80	5,460,000	2,730,000
		тэжээл	1,147.92	860,940,000	430,470,000
12.	Тээврийн зардал (төг)				82,022,450
Нийт дүн		өвс	1,171.05	929,672,480	464,836,240
		тэжээл	8,024.10	6,723,492,291	3,361,746,145
				7,735,187,221	3,908,604,835